

НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Биелэлт баталгаажуулсан:

Даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч

(албан тушаал)



Төсвийн Шууд захирагч

/Л.ДЭЛГЭР/

2023.12.11

(огноо)

Биелэлт хянасан:

Захиргаа төлөвлөлтийн
Ерөнхий менежер

(албан тушаал)

A handwritten signature in blue ink, likely belonging to B. Zolbajary, placed over a dotted line.

(гарын үсэг)

Нэгжийн дарга

/Б.ЗОЛБАЯР/

2023.12.11

(огноо)

Биелэлт нэгтгэсэн:

Төлөвлөлт, тайлан мэдээ
хариуцсан ажилтан

(албан тушаал)

A handwritten signature in blue ink, likely belonging to C. Yrelmaa, placed over a dotted line.

(гарын үсэг)

/Ц.ҮРЭЛМАА/

2023.12.11

(огноо)

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв (мян.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	ХШҮ-ний гүйцэт- гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Зорилт 1. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт – Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх							
1.1	Арга хэмжээ №1.1 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах, байгууллагын худалдан авалтад дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг дэмжих	-	Дотоодын бүтээгдэхүүний эзлэх хувь	70%-аас доошгүй байх	90%-аас доошгүй байх	Байгууллагын зоогийн газрын хүнсний бараа материалын 75 хувийг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээс худалдан авч, төрийн албан хаагчдад эрүүл, чанартай бүтээгдэхүүнээр хоол, зоогийн үйлчилгээг үзүүлсэн. Тус газарт 2023 онд эрх шилжсэн Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх ажил, үйлчилгээ байхгүй. 2023 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг газрын даргаар батлуулж, Сангийн яаманд хүргүүлэн төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллалаа. Үүнд: Зоогийн газарт хүнсний бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх болон цэвэрлэгээний бодис хэрэгсэл бэлтгэн нийлүүлэх тендерийг тус тус нээлттэй зохион байгуулсан боловч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтын дагуу бүх тендерээс татгалзан тендерийг дахин зарлан 2023 оны 06 сарын 02-ны өдөр дахин нийтэд нээлттэй зарлан сонгон шалгаруулалт явуулж бэлтгэл нийлүүлэгчийг сонгон шалгаруулсан.	75%
1.2	Арга хэмжээ №1.2 “Хурлын танхим захиалгын систем” цахим цэсийг үйлчилгээнд бүрэн нэвтрүүлж программын захиалгыг хүлээн авах, шаардлагатай хөгжүүлэлтийг тухай бүр хийж гүйцэтгэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100%	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем https://erp.ulaanbaatar.mn -д 2022 онд “Хурлын танхим захиалгын систем”ийг шинээр нэвтрүүлсэн. Тайлант онд тус цэсээр нийт 483 удаагийн хурлын танхимын захиалгыг цахимаар хүлээн авч мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласан байна.	100%
1.3	Арга хэмжээ №1.3 Албан бичгийг тоон гарын үсгээр илгээх, албан бичгийн харилцааг бүрэн цахимжуулж хэвшүүлэх, зөрчлийн тоог бууруулах	-	Зөрчлийн тоо	11	0	“eDOC” системийн баримт боловсруулалт модулийг ашиглан нийт 300 албан бичгийг цахим хэлбэрээр боловсруулан илгээж ажиллалаа. Тайлант онд хугацаа хэтэрсэн бичгийн тоо 6 буюу өмнөх оны мөн үетэй харьцуулбал таван зөрчлөөр буурсан үзүүлэлттэй байна.	100%

1	2	3	4	5	6	7	8
1.4	Арга хэмжээ №1.4 НЗЗ-ны байрууд, НҮНТ-ын салбарууд, дэд төвүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үйлчилгээний стандарт бүхий орчныг бүрдүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100%	Тайлант онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газартай 2023 оны 03 дугаар сарын 14-ны өдөр хамтран “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал” сэдэвт танхимын сургалтыг зохион байгуулсан. Сургалтад байр хариуцсан менежер, инженерээс бүрдсэн нийт 21 албан хаагч хамрагдаж өмнөх мэдлэгээ бататгасан. ХБХХЕГ хамтын ажиллагааны хүрээнд 4 ширхэг тэргэнцрийг хүлээн авч Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байр, НЗЗ-ны 1, 2, 5А байруудад хуваарилж байршуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэд төрийн үйлчилгээг авахад ээлтэй орчин нөхцөлийг бүрдүүлэн ажиллалаа.	100%
1.5	Арга хэмжээ №1.5 Төсөв, санхүүгийн ил тод байдлыг ханган Шилэн дансны тухай хууль, Шилэн дансны цахим хуудаст тавигдах журмын дагуу мэдээллийг цахим системд цаг хугацаанд нь байршуулж хэвших	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100%	Тайлант хугацаанд төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг дараа сарын 2-нд буюу нийт 12 удаа гарган Нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтэст, албан хаагчдын сар бүрийн НДШ төлөлтийн тайланг дараа сарын 5-ны дотор ЧД-ийн НДХэлтэст хуулийн хугацаанд нь буюу нийт 12 удаа илгээж баталгаажуулсан. Батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу зарцуулж, холбогдох 11 төрлийн тайлан мэдээг 111 удаа үнэн зөв, бодитой гарган, www.shilendans.gov.mn хуудаст тухай бүрд нь байршуулсан.	100%
1.6	Арга хэмжээ №1.6 Ажилтан, албан хаагчдыг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлига, хээл хахуулиас урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100%	Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдыг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгохоор Хууль эрх зүй, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан ажилтан 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр, 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр “Авлигын эсрэг хууль, тогтоомжийн хэрэгжилт, авлигын хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ” сэдвээр сургалтыг зохион байгуулж, сургалтад нийт 184 ажилтан, албан хаагч хамрагдлаа. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуулийн хүрээнд 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр “Алтан хонх”, “Авлигыг таслан зогсооход хүн бүрийн оролцоо чухал” сэдвээр АХА тэмцээнийг нийт 253 ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулан хуулийг сурталчлан таниулж, авлига, хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхийг уриалан, хуулийн мэдлэг олголоо.	100%

1	2	3	4	5	6	7	8
1.7	Арга хэмжээ №1.7 ХНХТ-тэй хамтран байгууллагын ажилтан, албан хаагчдыг ажил үүргийн чиглэлээр сургалтад хамруулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100%	Тайлант онд Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан 13 сургалтад ажил үүргийн чиглэлийн дагуу давхардсан тоогоор нийт 384 ажилтан, албан хаагчийг хамруулсан.	100%
1.8	Арга хэмжээ №1.8 Чанарын менежментийн тогтолцоо– Шаардлага MNS ISO 9001:2016 стандартыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлыг үе шаттай эхлүүлэх ажлыг зохион байгуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100%	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны А/11, 17 дугаар тушаал, газрын даргын “Дэд ажлын хэсэг байгуулах тухай” А/12 дугаар тушаал А/14 дүгээр тушаалаар “Чанарын менежментийн тогтолцооны MNS 9001:2016 стандарт нэвтрүүлэх хамрах хүрээ, ажлын төлөвлөгөө”-г тус тус батлуулсан. “Менежмент ба ур чадварын хүрээлэн” ТББ-ын зөвлөх багштай хамтран Чанарын менежментийн тогтолцоо– Шаардлага MNS ISO 9001:2016 стандартыг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх хэрэгжилтийг ханган нарийвчилсан төлөвлөгөөний төлөвлөх үе шатны 10 бүлгийн 19 багц сургалтад нийт 147 ажилтан, албан хаагч хамрагдаж, процессын алхмуудыг тухай бүр хийж гүйцэтгэсэн. Стандарт нэвтрүүлэх ажлын хүрээнд 24 баримт бичиг 4 журам, процессын эмхэтгэл, чанарын гарын авлагыг боловсруулж эхний хувилбараар процессын эмхэтгэл, чанарын гарын авлагыг холбогдох дээд газарт хүргүүлэн ажиллалаа. Стандарт нэвтрүүлэх ажлын явцын шинжилгээ, хэрэгжүүлэх үе шат төлөвлөгөөний дагуу бүрэн хэрэгжсэн. Мөн 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрүүдэд “ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо” нэвтрүүлэх ажлын хүрээнд аудитор бэлтгэх сертификаттай танхимын сургалтад 5 албан хаагч хамрагдан гардан авлаа.	100%
1.9	Арга хэмжээ №1.9 “Нутгийн захиргааны байгууллагуудын цэвэрлэгээ үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага” UCS0201B:2020 удирдамж арга зүйн баримт бичгийг цэвэрлэгээ, үйлчилгээндээ мөрдлөг болгон ажиллах, сурталчлан таниулах сургалтыг зохион байгуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100%	Тайлант онд НЗЗ-ны 5-н байр, НҮНТ-ийн 4-н салбар, Баянхошуу, Сэлбэ дэд төв, Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор байрны нийт 61.395м.кв талбайн өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээнд UCS0202B:2020 “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын цэвэрлэгээ, үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага” стандартыг мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллалаа. Шинээр ажилд орсон нийт 26 үйлчилгээний ажилтанд тухай бүрд нь дээрх стандартыг танилцуулж, цэвэрлэгээ үйлчилгээнд мөрдлөг болгон ажиллууллаа.	100%

1	2	3	4	5	6	7	8
1.10	<p>Арга хэмжээ №1.10</p> <p>Ажилтан, албан хаагчдыг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлига, хээл хахуулиас урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах 2023 онд байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллах</p>	-	Авлига, ашиг сонирхлын зөрчлийн тоо	0	0	<p>Газрын даргаар 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдөр “Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлуулан, төлөвлөгөөний хэрэгжилтийг ажиллалаа. Төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувь. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар тус газрын хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалын 12 албан хаагч Авлигатай тэмцэх газарт заасан хугацаанд ХАСУМ, ХАСХОМ-ийг Авлигатай тэмцэх газарт заасан хугацаанд нь мэдүүлсэн. Засгийн газрын 49 дүгээр тогтоол “2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай”-г хяналтад авч, холбогдох албан хаагчдад танилцуулж мэдээллээр ханган ажиллалаа. Тус тогтоолын хүрээнд 2023 оны 05 сарын 01-ний өдрөөс 06 сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд “Би өгөхгүй, авахгүй” нөлөөллийн аяныг зохион байгуулж нийт ажилтан, албан хаагчид, нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдыг уриалан ажиллалаа.</p>	100%
1.11	<p>Арга хэмжээ №1.11</p> <p>Найрсаг Улаанбаатар арга хэмжээний хүрээнд ажилтан, албан хаагчдын дунд найрсаг харилцаа, хандлагыг төлөвшүүлж хотын соёлыг дэлгэрүүлэх, ёс зүйг сайжруулах сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах</p>	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100%	<p>- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын дагуу 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 07-ны өдрүүдэд “Эрүүл мэндийн цахим гүйлт 2023” биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулсан. Тус арга хэмжээний STRAVA аппликейшнд 23 ажилтан, албан хаагч хамрагдан нийт 280 км замыг туулж амжилттай оролцсон.</p> <p>- Ажилтан, албан хаагчдын дунд найрсаг харилцаа, хандлагыг төлөвшүүлэх зорилгоор спортын дөрвөн төрөлт тэмцээнийг 2023 оны 05 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулж, нийт 10 багийн 290 тамирчин хурд хүч, авхаалж самбаагаа сорин идэвхтэй оролцсон. Тэмцээнд оролцсон багуудаас нийлбэр дүнгээрээ тэргүүн байранд НЗЗ-ны 2 дугаар байрны “Хангарди” баг шалгарч “ШИЛЖИН ЯВАХ ЦОМ - 2023”-ын эзэн болсон бол дэд байранд ЗТХХ-ийн “Galaxy” баг, гутгаар байранд ННЗТЦБ-ны “Golden team” баг тус тус шалгарсан.</p> <p>- Мөн найм дахь жилдээ зохион байгуулагдаж буй “Улаанбаатар Марафон - 2023” олон улсын гүйлтийн тэмцээн 2023 оны 06 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулагдаж, тус арга хэмжээнд байгуул-</p>	100%

1	2	3	4	5	6	7	8
						<p>лагын нийт 16 ажилтан, албан хаагч идэвхтэй оролцлоо.</p> <p>- Нийслэлийн Засаг даргын нэрэмжит Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын “Спортын IV наадам” 2023 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулж, тэмцээнд байгууллагын 4 төрөлт тэмцээнд амжилттай оролцсон.</p> <p>- Хүний нөөцийн хөгжлийн төвөөс 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан “Ёс зүй”-н сургалтад 2 албан хаагчийг хамруулсан.</p>	
Зорилт 2. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт							
2.1	<p>Арга хэмжээ №2.1</p> <p>Ажилтан, албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг хангах, баяжуулалтыг цаг тухайд нь хийх, холбогдох судалгааг тухай бүр гаргах</p>	13	Гаргасан судалгааны тоо	13	17	<p>Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолын дагуу ажилтан, албан хаагчдын хувийн хэргийг шинэчилж, шинээр томилогдсон 44 ажилтан, албан хаагчийн хувийн хэрэг үүсгэх, холбогдох баримт бичгийн бүрдлийг ханган ажилласан.</p> <p>Тайлант хугацаанд хүний нөөцийн нэгдсэн www.hr.csc.gov.mn системд ажилтан, албан хаагчдын албан тушаал, үндсэн цалин, боловсрол, ажлын туршлага, ур чадвар, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, ажил хавсран гүйцэтгэсэн, шинээр ажилд орсон ажилтан, албан хаагчийн хувийн шилжих хөдөлгөөнийг бүртгэж, тухай бүр шинэчилж оруулсан. Хүний нөөцийн чиглэлээр нийт 18 судалгааг шинэчлэн нэгтгэсэн. Мөн байгууллагад олон жил үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажилласан нийт 27 ажилтан, албан хаагчийн тодорхойлолтыг бэлтгэн холбогдох яамд, НИТХ, НЗДТГ-т хүргүүлж, 26 ажилтан, албан хаагчийг шагнаж урамшуулсан.</p>	18
2.2	<p>Арга хэмжээ №2.2</p> <p>Сул орон тоог тогтмол зарлах холбогдох хууль, журмын дагуу нөхөн бүрдүүлэлт хийх</p>	-	Хүний нөөцийн бүрдүүлэлтийн коэффициент	0.6	0.6-аас ихгүй байх	<p>Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр ажлын байрны сул орон тооны зарыг байгууллагын цахим хуудас www.khangardi.mn болон зарын нэгдсэн цахим хуудас www.unegui.mn, www.biznetwork.mn байгууллагын мэдээллийн самбарт тогтмол байршуулж ажиллалаа. Мөн Нийслэлийн Хөдөлмөр, халамжийн газар, дүүргүүдийн Хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэстэй хамтран ажлын байрны сул орон тооны зарыг тогтмол хүргэн ажиллаж байна. Тайлант хугацаанд 13 ажлын байрны 43 сул орон орон тоонд</p>	0.6

1	2	3	4	5	6	7	8
						85 ажил горилогч материалаа ирүүлж, нөөцөд бүртгэгдсэн бөгөөд анкет, хувийн хэргээс сонгон шалгаруулалт хийж нийт 79 иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн ажлын байрны сул орон тоонд зохих шаардлагыг хангасан 8 ажилтныг албан тушаалд дэвшүүлэн томилсон.	
2.3	Арга хэмжээ №2.3. Ажилтан, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг хагас жилээр дүгнэж, цаашид авах арга хэмжээний саналыг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэх	4	Гүйцэтгэл, үр дүнг дүгнэсэн тоо	2	2	Тайлант онд ажилтан, албан хаагчдын ур чадварын нэмэгдэл, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг сар бүр тооцон нийт 955794,8 мянган төгрөгийг олгосон. Газрын даргын 2023 оны А/55 дугаар тушаалын дагуу нийт 253 ажилтан, албан хаагчаас 214 буюу 85 хувь нь 25%, 15 буюу 6 хувь нь 20%, 4 буюу 2 хувь нь 15%, 2 буюу 1 хувь нь 10%-тай дүгнэгдэж, 18 ажилтан, албан хаагч шинээр орсон болон бусад шалтгаанаар дүгнэгдээгүй. Гүйцэтгэл, үр дүнг дүгнэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	2
2.4	Арга хэмжээ №2.4 Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын 2021-2024 онд хэрэгжүүлэх хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах, сургалт, нийгмийн баталгааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100%	Тайлант хугацаанд байгууллагын дотоод журамд заасны дагуу 12 ажилтан, албан хаагчид байгууллагад гаргасан хүсэлтийг нь үндэслэн нийт 4300,0 мянган төгрөг, Цагаан сар, Ахмадын баяраар 105 өндөр настанд хүндэтгэл үзүүлэх зардалд нийт 10650,0 мянган төгрөг, өндөр настны тэтгэвэрт гарсан 6 ажилтан, албан хаагчид нэг удаагийн тэтгэмжид нийт 109586.6 мянган төгрөгийн мөнгөн тусламж тус тус үзүүлсэн.	100%
2.5	Арга хэмжээ №2.5 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй, хэмнэлттэй зарцуулж, санхүүгийн тайлан мэдээг хугацаанд нь тайлагнаж ажиллах	-	Өр, авлагагүй ажилласан байх	Өр авлагагүй ажилласан	Өр авлагагүй ажиллах	Батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу зарцуулж, холбогдох тайлан мэдээг тогтоосон хугацаанд нь гарган шилэн дансны тухай хуулийн дагуу цахим хуудаст байршуулан ажиллалаа.	Өр авлагагүй ажилласан
2.6	Арга хэмжээ №2.6 Байгууллагын ажилтан, албан хаагчдын цалин хөлсийг цаг тухай бүр нь олгох	-	Цалин бодож олгосон тоо	0	12	ТАЦНС-д нийт ажилтан, албан хаагчдын цалингийн тооцоо, бүртгэл мэдээллийг холбогдох тушаал шийдвэрийн дагуу программд оруулан тооцоолол хийж тайлант хугацаанд нийт 12 удаа цалин олгосон. Нийгмийн даатгалын тайланг нийт 12 удаа тайлагнан, ЧД-ийн нийгмийн даатгалд цаасан сууриар хүргүүлж баталгаажуулсан.	100%
2.7	Арга хэмжээ №2.7 2023 онд байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллах	-	Авлига, ашиг сонирхлын зөрчлийн тоо	0	0	Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдөр газрын даргаар батлуулсан. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг шинэчлэх ажлын хүрээнд хууль эрх зүй - тогтоол шийдвэрийн	

1	2	3	4	5	6	7	8
						хэрэгжилт хариуцсан ажилтан 2023 оны 01 сарын 12-ны өдөр ХАСХОМ мэдүүлэх үүрэгтэй албан хаагчдад сургалт зохион байгуулан мэдээлэл, арга зүйгээр ханган ажиллалаа.	
2.8	Арга хэмжээ №2.8 Байгууллагын ажилтан, албан хаагчдын сахилга хариуцлага, харилцаа хандлагыг дээшлүүлэх, ёс зүйг сахиулах	-	Зөрчлийн коэффициент	0.01	0 ихгүй байх	Тайлант онд ёс зүйн зөвлөл хуралдан 6 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн. Үүнээс сахилгын зөрчил 4 байгаагаас холбогдох ажилтан, албан хаагчдад Хөдөлмөрийн тухай хуулийн 123.2.1.өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр хаалттай сануулах, 123.2.3.үндсэн цалинг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах; 123.2.5.ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах арга хэмжээг авсан.	0.01
2.9	Арга хэмжээ №2.9 Байгууллагын болон нэгжүүдийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлж ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100%	Тайлант онд төлөвлөгөөний дагуу газрын даргын томилсон ажлын хэсэг гарч эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, зоогийн газар, цайны газруудын үйл ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, байр ашиглалт, цэвэрлэгээ, үйлчилгээний чанар стандартад хяналт шалгалт хийж гүйцэтгэн гарсан зөрчил дутагдлыг илрүүлж, хугацаатай үүрэг даалгаврыг өгч ажилласан.Тухайлбал: - Газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/07 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар баталсан удирдамжийн дагуу НЗЗ-ны байруудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж гүйцэтгэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг хангуулсан. - 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр баталсан удирдамжийн дагуу байгууллагын дотоод үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж засаж сайжруулах зөвлөмжийг танилцуулан хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. - 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр баталсан удирдамжийн дагуу зоогийн газрын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, дүнг газрын даргад танилцуулан, холбогдох албан хаагчдад ажил сайжруулах хугацаатай үүрэг даалгаврыг өгч, зөрчил дутагдлыг арилгуулан ажиллалаа. - 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр баталсан удирдамжийн дагуу “Зоогийн газрын санхүүгийн төлбөр тооцооны /касс/-ын үйл ажиллагаанд”	100%

1	2	3	4	5	6	7	8
						хэсэгчилсэн хяналт шалгалт зохион байгуулж, үр дүнг илтгэх хуудсаар газрын даргад танилцуулж холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. - 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн удирдамжийн зоогийн газрын ажилтан, албан хаагчдын хариуцдаг эд хөрөнгийн бүртгэлийг тулгаж, карталж “Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ”-нд заасны дагуу хариуцсан эд хөрөнгөд хариуцлагатай ажиллахыг мэдэгдсэн.	
2.10	Арга хэмжээ №2.10 Бодлогын болон захирамжлалын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, холбогдох тайлан мэдээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100%	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 7 заалт, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 3 заалтад нийцүүлэн, Монгол Улсын 5 хуулийн 8 заалт, Засгийн газрын 8 тогтоолын 18 заалт, Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгаврын 1 заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2 тогтоолын 2 заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2 тогтоолын 2 заалт, Нийслэлийн Засаг даргын 4 захирамжийн 4 заалт, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын 3 тэмдэглэлийн 6, нийт 42 заалтыг хяналтад авч, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нийт заалтуудын бүрэн хэрэгжилтийг хангаж ажиллалаа.	100%
2.11	Арга хэмжээ №2.11 Иргэд, албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг холбогдох хууль тогтоомж, журмын хүрээнд шийдвэрлэх, өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах		Өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд гарсан зөрчил	14	0	НЗД-ын 2022 оны А/1049 дүгээр захирамжаар ажилтан, албан хаагчдаас нийт 220 өргөдөл ирснийг системд бүртгэн, 219 өргөдлийг бүрэн шийдвэрлэж хариуг өргөдөл гаргагчид танилцуулсан бол 1 өргөдөл шийдвэрлэх шатанд байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 7 хоног, 10 цаг, 44 минут. Өргөдлийг хандалтын төрлөөр нь ангилбал: - Хөдөлмөрийн хөлстэй холбоотой өргөдөл - 45, - Захиргааны чөлөө хүссэн өргөдөл - 32, - Ажилд орох, чөлөөлөгдөхтэй холбоотой өргөдөл - 85, - Жирэмсний болон хүүхэд асрах чөлөө хүссэн өргөдөл - 15, - Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай өргөдөл – 30, - Ажилд шилжин, дэвшин ажиллах тухай өргөдөл – 8 - Ажлын сахилга, хариуцлагын тухай – 3, - Бусад – 2	11

1	2	3	4	5	6	7	8
						Өмнөх оны мөн үетэй харьцуулбал шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2 хоногоор, өргөдлийн тоон үзүүлэлт 15 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	
2.12	Арга хэмжээ №2.12 Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд зохион байгуулах, албан хаагчдыг баримт бичиг боловсруулахад "Баримт бичгийн стандарт" MNS 5140:2021 стандартыг мөрдүүлэх, хяналт тавих	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100%	- Тайлант хугацаанд явсан бичиг 300, ирсэн албан бичиг 344 үүнээс хариутай бичиг 100, хариугүй бичиг 244, хугацаа хэтэрсэн 6, шийдвэрлэлтийн хувь 100% байна. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гаргасан газрын даргын А тушаал 55, Байгууллагын хүний нөөцийн чиглэлээр гаргасан даргын Б тушаал 345 тус тус гарсан. - Байгууллагын 2022 оны үйл ажиллагаанд нэгжүүдээс үүсэж хөтлөгдсөн 70 жил хадгалах 19, байнга хадгалах 30, түр хадгалах 124 буюу нийт 173 хадгаламжийн нэгжийг "Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын архивын дүрэм", "Байгууллагын архивын ажлын үндсэн заавар"-ын дагуу ангилж нэр төрөл хугацаагаар нь төрөлжүүлсэн. - Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх архив, албан хэрэг хөтлөлтийн журам болон байгууллагын архивын дүрмийг боловсруулсан. - Байгууллагад хөтлөгдөх 109 нэр төрлийн баримтаас, байнга хадгалах баримт - 48, түр хадгалах баримт - 55, 70 жил хадгалах баримт-6 2023 онд үүсэхээр хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж батлуулсан.	100%
2.13	Арга хэмжээ №2.13 НЗЗ-ны байруудад гамшгаас хамгаалах төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг зохион байгуулах	-	Эрсдэлийн үнэлгээ хийгдсэн тоо	0	1	Тайлант онд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Онцгой байдлын газартай хамтран 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулсан "Газар хөдлөлтийн гамшиг", "Гал түймрийн аюул" сэдэвт танхимын болон дадлагын сургалтад нийт 45 албан хаагч хамрагдаж мэдлэг, ур чадвараа дээшлүүллээ. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 399 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохио дамжуулах журам", 340 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Үндэсний аюулгүй байдлын удирдлага дор 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан "Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдож "Онц байдал" тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан ажиллагаа" сэдэвт стратегийн команд	100%

1	2	3	4	5	6	7	8
						штабын сургуулилтад нийт 187 ажилтан, албан хаагч идэвхтэй оролцлоо.	
2.14	Арга хэмжээ №2.14 Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг цахим хуудас www.khangardi.mn болон мэдээллийн самбарт байршуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100%	Байгууллагын цаг үеийн шинж чанартай мэдээ, мэдээллийг www.khangardi.mn цахим хуудаст тухай бүр буюу нийт 29 удаа байршуулан байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажилласан.	100%
2.15	Арга хэмжээ №2.15 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих арга хэмжээнд идэвхтэй оролцох	-	Арга хэмжээний тоо	0	1	Монгол Улсын Ойн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Ногоон хот-Иргэний оролцоо” хаврын мод тарих аянд нэгдэн 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдөр “Баянгол цэцэрлэгт хүрээлэн”-д 170 ширхэг хайлаас мод тарьж, модны арчилгаа, усалгааг хийж гүйцэтгэсэн. Мөн “Ногоон хот-Иргэний оролцоо” намрын мод тарих аян нэгдэн 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдөр “Баянгол цэцэрлэгт хүрээлэн”-д нийт 16 ажилтан, албан хаагч очиж хаврын тарьсан модны арчилгаа, усалгаа, нөхөн сэргээлтийг хийсэн.	100%
2.16	Арга хэмжээ №2.16 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг дээд шатны байгууллагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулах, ажилтан, албан хаагчдыг мэдээллээр ханган ажиллах	-	Сургалт, мэдээллээр ханган ажилласан тоо	-	1	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хар тамхитай тэмцэх газраас 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтад нийт 45 ажилтан, албан хаагчийг хамруулсан.	100%
2.17	Арга хэмжээ №2.17 Жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, хохирогч, гэрчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр сургалт зохион байгуулж, мэдээллээр хангах	-	Сургалт, мэдээллээр ханган ажилласан тоо	-	1	Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Жендерийн үндэсний хорооноос 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх 1 сарын хугацаанд зохион байгуулагдсан “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” үндэсний хэмжээний төслийн “Харилцан хүндэтгэе” аянд хамт олноороо нэгдэн, нийт 15 байршилд тус аяныг сурталчлан ажиллалаа.	100%
Зорилт 3. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт							
3.1	Арга хэмжээ №3.1 Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудад санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээг агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч, тооцооны нягтлан, нярваар дамжуулан үзүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100%	Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч 11 агентлагт агентлаг хариуцсан 5 ахлах нягтлан бодогч, 1 тооцооны нягтлан бодогч, 4 нярваар дамжуулан санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээг үзүүлж, байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааг хэвийн явагдах нөхцөлөөр ханган ажиллалаа.	100%

1	2	3	4	5	6	7	8
3.2	Арга хэмжээ №3.2 Агентлагуудын санхүүгийн тайлан мэдээг, үнэн зөв хугацаанд нь гаргах, зөрчил дутагдлыг бууруулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100%	Тайлан, мэдээг хуулийн хугацаанд гарган https://shilendans.gov.mn цахим хуудаст тухай бүр байршуулан ажилласан. Мөн 11 агентлагийн хэмжээнд 2023 оны батлагдсан төсвийг үр ашигтай төлөвлөн зарцуулж өглөг, авлага үүсэхгүй батлагдсан төсвийн хуваарийн дагуу гүйцэтгэл хийх чиглэл өгч ажиллалаа.	100%
3.3	Арга хэмжээ №3.3 Нийслэлийн засаг захиргааны байрууд, дэд төвүүдийн инженерийн байгууламжийн хэвийн найдвартай ажиллагааг ханган ажиллах, гэрээний дагуу төлбөрийг төвлөрүүлэх	26.1	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100%	НЗЗ-ны 6-н байранд байрлах Нийслэлийн нутгийн захиргааны 36 агентлагтай “Байр ашиглалтын гэрээ” болон “Гүйцэтгэх гэрээ” байгуулан гэрээний дагуу ажил, үйлчилгээг үзүүлж ажилласан ба гэрээт байгууллагуудын ашиглалт, үйлчилгээний төлбөрийн тооцоог сар бүрийн эхэнд нэхэмжлэхээр хүргүүлж, орлого төвлөрүүлэлтэд тулгалт хийн тооцоо нийлж 258319,3 төгрөг буюу орлогоо 100 хувь төвлөрүүлсэн байна. Тайлант онд байруудын ус, дулаан, цахилгаан, мужааны засвар үйлчилгээ, инженерийн байгууламжийн хэвийн, жигд ажиллагааг ханган ажиллалаа. Цахилгааны гэмтэлтэй холбоотой 2185, сантехникийн эвдрэл гэмтэлтэй холбоотой 1469, мужааны үйлчилгээтэй холбоотой 1685, холбоо, дохиоллын 302 нийт 5641 дуудлага ирснийг шуурхай шийдвэрлэж ажилласан ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	100%
3.4	Арга хэмжээ №3.4 Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байрны инженерийн шугам сүлжээний хэвийн ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэхийн тулд шаардлагатай завсар үйлчилгээг гүйцэтгэгч компаниар чанартай хийж гүйцэтгүүлэх, хяналт тавих	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100%	Тайлант онд дараах засвар үйлчилгээнүүдийг хийж гүйцэтгэлээ. Үүнд: - Цэвэр усны нөөцийн 90м3-н багтаамжтай хуванцар савыг 2023 оны 05 дугаар сарын 19,20-ны өдрүүдэд цэвэрлэгээ үйлчилгээ ариутгалыг хийж гүйцэтгэсэн; - Бохир ус зайлуулах өргөлтийн насос станц үерийн усаар дамжин хайрга, лаг шавраар дүүрсэн байсныг 2023 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр нийт 18м3 лагийг соруулж цэвэрлэж, үрэгдэн ажлын дугуй цоорсныг шинээр резерв насосоор сольж суурилуулсан; - Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байрны барилгын ажлыг хийж гүйцэтгэсэн “Темпланд” ХХК-наас 2023 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 23/177 тоот албан мэдэгдлийн дагуу TD-125-40-4, TD-80-38-2, TD-100-40-2 маркийн 3-н ширхэг өргөлтийн насосын ажлын дугуй, фланцны жийргэвчийг засварлаж хэвийн болгосон; - КНС-ны өргөн насос эвдэрснийг УСУГ-тай хамтран	100%

1	2	3	4	5	6	7	8
						2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр нийт 68тн бохирыг соруулж, насосыг шинээр худалдан авч суурилуулж хэвийн ажиллагааг ханган ажилласан; - А1 блокийн В1 давхрын техникийн өрөө халаалтгүйгээс шал хөлдөж, 101,102,103,104-р өрөөнүүдийн цонхны завсраар давхар хоорондын дулаан солилцоо алдагдсаныг "Темпланд" ХХК, ННЗЦБАӨЗ-нд мэдэгдэж нийт 190 м2 талбайд халаалт шинээр суурилуулсан;	
3.5	Арга хэмжээ №3.5 Нийслэлийн засаг захиргааны байрууд, дэд төвүүдийн аюулгүй байдлыг хангах, 24 цагийн камерын хяналт тавих	-	Байруудад гарсан зөрчлийн тоо	0	0	НЗЗ-ны байруудын аюулгүй байдлыг хангах үүднээс жижүүр, харуул хамгаалалтын ажилтнууд камерын хяналтыг 24 цагийн турш хийж гүйцэтгэж байна. Тайлант хугацаанд харуул, хамгаалалттай холбоотой зөрчил, дутагдалгүй ажилласан. Тухайлбал: - НЗЗ-ны 3-р байрны хяналтын 3 камер, 1 ширхэг бичигч төхөөрөмжид /NVR/ засвар үйлчилгээг хийж, хэвийн ажиллагааг ханган ажилласан. - НЗЗ-ны 5А,Б,В байруудын бичигч төхөөрөмж /NVR/-ийг 5ш, 16 порттой свич 2ш, байрны гадна, дотор 6ш хяналтын камер, байгууллагын архивын өрөөний 4ш камерыг тус тус шинээр сольж хэвийн ажиллагаанд оруулсан. - Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байрны хяналтын камерын 5 дугаартай бичигчийн 3 хард диск шатсаныг сольж хэвийн ажиллагаанд оруулсан. - НЗЗ-ны 2, 3, 4 дүгээр байр болон Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байрны хяналтын камерын төхөөрөмжүүдийн нууц үгийг сольсон. - НЦХМТГ, "ПроGRID систем" ХХК-тай хамтран гурвалсан гэрээ хийн 1 жилийн эрхтэй антивирусын эрхийн хугацааг сунгаж, ESET PROTECT Essential программыг 30 ширхгийг авч албан хаагчдын компьютерт суулгасан.	100%
3.6	Арга хэмжээ №3.6 Ажилтан, албан хаагчдыг хамгаалах багаж хэрэгслээр хангаж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгөх, сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах, хяналт тавих	18.9	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100%	Цэвэрлэгээ, үйлчилгээний чанарыг сайжруулах, хөдөлмөрийг хөнгөвчлөх үүднээс нийт байруудаас багаж, тоног төхөөрөмжийн судалгааг авч хивс угаагч машин 1 ширхэг, тоос сорогч 4 ширхэг, гадна талбайн дугуйтай хогийн тэрэг 11 ширхэг, сэгсрэгчтэй хувин 50 ширхэг зэрэг шаардлагатай хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангалаа. Тайлант хугацаанд 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр НЗЗ-ны байруудын галын аюулгүй байдал, ажлын	100%

1	2	3	4	5	6	7	8
						байрны орчны аюулгүй байдал зэрэгт дотоод хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн. Газрын даргын 2023 ны А/06 дугар тушаалаар баталсан удирдамжийн дагуу ХАБЭА-н өдөр тутмын зааварчилгааны арга зүй, гарын авлагын загварыг боловсруулж байр хариуцсан менежерүүдэд хүлээлгэн өгсөн. Инженер техникийн болон зоогийн газрууд, үйлчилгээний нийт ажилчдад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч, хөдөлмөр хамгааллын дэвтэр хөтлөлтөд хяналт тавин ажилласан. - Мөн 4-н байшилд байх зоог, цайны газруудын галын аюулгүй байдал, зоогийн газрын эрүүл ахуйн ажиллагаанд ээлжит шалгалтыг хийж, тус бүр заавар өгч, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.	
3.7	Арга хэмжээ №3.7 “Хөдөлмөр хамгааллын осолгүй манлайлал” ажлын байрны болзолт уралдаан зохион байгуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100%	Тайлант хугацаанд 2023 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн докторант судлаач Г.Эрдэнэтөгсийг урин “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй” сэдэвт танхимын сургалтыг зохион байгуулж нийт 170 ажилтан, албан хаагчийг хамруулж, мэдээлэл арга зүйгээр ханган ажиллалаа. Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр тушаалаар “Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг, шинжилгээ, оношлоогоог зохион байгуулах журам”-ын дагуу Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хооронд эрт илрүүлэг, эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулж нийт 272 албан хаагч хамрууллаа.	100%
3.8	Арга хэмжээ №3.8 Нийслэлийн засаг захиргааны байруудын хуралдааны танхимуудын техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангах, гомдол саналгүй ажиллах	-	Техник хэрэгслийн гэмтэл засварласан тоо	10	0	Тайлант онд дараах байршлуудын хуралдааны танхимуудад зохион байгуулагдсан нийт 1246 арга хэмжээний бэлтгэл ажлыг хангаж, зөрчил, доголдолгүй хэвийн ажиллагааг хангаж ажиллаа. Тухайлбал: - НЗДТГ буюу НЗЗ-ны 1 дүгээр байрны хурлын заалаар нийт 535 хурал, уулзалтын захиалга ирснээс А танхимд хурал - 398, Б танхимд шагнал гардуулах ёслолын үйл ажиллагаа - 95, VIP танхимд тусгай уулзалт - 42;	100%

1	2	3	4	5	6	7	8
						<p>- НЗЗ-ны 2-р байр буюу Хангарди ордны 14 давхрын хурлын танхимаар нийт 591 хурал, уулзалтын захиалга ирснээс НИТХ-ын ээлжит болон ээлжит бус чуулган - 20, НЗД-ын Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн – 31, НЗД-ын дэргэдэх удирдлагын зөвлөлийн хурал – 19, ЗАА шуурхай зөвлөгөөн – 25, шагнал гардуулах үйл ажиллагаа - 28, бусад харьяа байгууллагуудын хурал, зөвлөгөөн, семинар, сургалт – 468;</p> <p>- НЗЗ-ны 5-р байрны В корпуст нийт 122 удаагийн хурал, хэлэлцүүлгийн захиалга ирснээс хурал, семинар - 52, сургалт – 46, зөвлөгөөн - 2, шагнал - 16, хэлэлцүүлэг – 5, техникийн зөвлөгөөн – 1;</p>	
3.9	Арга хэмжээ №3.9 Байруудын нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, ногоон байгууламжийн арчлалт, шинэчлэлийн ажлыг гүйцэтгэх	-	Тохижилт, ногоон байгууламж хийгдсэн тоо	14	15	НЗЗ-ны байруудын гаднах орчны аюулгүй байдлыг ханган өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээг хийж гүйцэтгэн тухайн байруудын гаднах нийтийн эзэмшлийн зам талбайг халтиргаа гулгаанаас урьдчилан сэргийлж, орчны 50 метр хүртэлх 31,450 кв талбайн цас, мөс цэвэрлэх, өдөр тутмын болон дээврийн цэвэрлэгээг нийт 152 удаа, их цэвэрлэгээг 678 удаа тус тус хийж, эхний хагас жилийн байдлаар нийт 3694 удаа гадна талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хийж ажиллалаа.	15
3.10	Арга хэмжээ №3.10 Байруудын нийтийн эзэмшлийн талбайд шаардлагатай засвар, үйлчилгээг батлагдсан төсөвтөө багтаан хийж гүйцэтгэх	560.1	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100%	<p>Тайлант онд байруудын нийтийн эзэмшлийн талбайд шаардлагатай засвар, үйлчилгээг дараах байдлаар хийж гүйцэтгэн байруудын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллалаа. Тухайлбал:</p> <p>- НЗЗ-ны 1, 2 дугаар байрны халаалтын шугам хоолой, ариун цэврийн өрөөний кабин, хэрэгцээний хүйтэн усны татах реле зэрэг гэнэтийн эвдрэл, гэмтлийг тус тус шуурхай засварлан ажиллалаа.</p> <p>- Газрын даргын баталсан инженерийн шугам сүлжээнд үзлэг шалгалт хийх хуваарийн дагуу гэмтлээс шалтгаалсан ус, дулааны алдагдлыг багасгахаар сар бүр НЗЗ-ны байруудын халаалт, хэрэглээний халуун, хүйтэн усны шугам хоолойг шалган хяналт тавин ажиллалаа.</p> <p>- Нийслэлийн засаг захиргааны 2, 4 дүгээр байр болон Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байрны хүн зөөврийн болон ачааны нийт14 цахилгаан шатны хэвийн найдвартай үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж, сар бүр буюу нийт 12 удаа “Сима Тех” ХХК, “Хан хөгшин трейдинг” ХХК, “Би Эм Эн Би элеватор” ХХК зэрэг гэрээт</p>	100%

1	2	3	4	5	6	7	8
						байгууллагаар ашиглалт, засвар үйлчилгээг гүйцэтгүүлж, цахилгаан шатны аюулгүй ажиллагааг ханган ажиллалаа. - НЗЗ-ны байрны 0,4квтын ерөнхий щитны оруулгын рубелник ХТП0478 станцын 2 сецкийн 4 ячак тасарсныг залгаж хэвийн ажиллагааг ханган ажиллалаа. - НЗЗ-ны 1 дүгээр байрны 2, 3 давхрын нийтийн эзэмшил, 5А байрны 1 давхрын нийтийн эзэмшилд тус тус засварын ажлыг хийж гүйцэтгэн төрийн албан хаагчдын ая тухтай ажиллах орчныг бүрдүүллээ. - ННЗТЦБ-нд байрлах цэвэр усны нөөцийн 90м ³ -н багтаамжтай савыг цэвэрлэж, ариутгалаа. - НЗЗ-ны 5В байрны 2 давхарт НБИХГ-ын 1 ажлын өрөөнд дээврийн борооны усны зайлуулахаас ус алдсаныг шуурхай засварлан ажиллалаа. - НЗЗ-ны 1 дүгээр байрны В1 давхарт халаалтын шугамын буцах шугам цоорсныг засварлаж, мөн бохирын шугам хоолой бөглөрч гадна худаг хөлдсөнийг хэвийн болгон засварласан. - Байруудын чанарын шаардлага хангахгүй болсон гэрэл чийдэн, бусад тоног төхөөрөмжийг эрчим хүчний хэмнэлтэй лед гэрлээр сольж, гадна фасадын гэрлийг цагийн релегээр тохируулсан.	
3.11	Арга хэмжээ №3.11 НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбарууд, дэд төв, Нийслэлийн нутгийн захиргаан төв цогцолбор байрны гадна, дотор орчинд цэвэрлэгээ, үйлчилгээг стандартын дагуу үзүүлэх	803.03	Цэвэрлэгээ, үйлчилгээ хийх талбайн хэмжээ /м2/	61,395	61,395	НЗЗ-ны 5-н байр, ННҮТ-ийн 4-н салбар, Баянхошуу, Сэлбэ дэд төв, Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байрны нийт 61.395 мкв талбайн өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээ үзүүлж, 8520 удаа, ариун цэврийн өрөөний цэвэрлэгээг 8520 удаа, хуваарийн дагуу их цэвэрлэгээг 579 удаа тус тус хийж гүйцэтгэсэн.	61,395
3.12	Арга хэмжээ №3.12 Байруудад хог хаягдлыг ангилан ялгах ажлыг хэвшүүлэх, сайжруулах	-	Ангилан ялгасан хог хаягдлын хувь	5	20	Хог хаягдлыг хуванцар, лаазаар нь 2 ангилж нийт 130кг хуванцар сав, 20кг лаазыг ангилан бэлтгэж хог тээвэрлэлтэд ачуулсан.	100%
3.13	Арга хэмжээ №3.13 Эрүүл ахуйд нийцсэн зоогийн үйлчилгээг төрийн албан хаагчдад үзүүлэх	2019.1	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100%	Тайлант онд Хангарди ордны зоогийн газар, НЗДТГ, Улаанбаатар театр, Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байрны цайны газруудаар дамжуулан давхардсан тоогоор 56553 хүнд нийтийн хоолны үйлчилгээг стандартын дагуу, эрүүл, чанартай хүнсний бүтээгдэхүүнээр бэлтгэн, мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэн ажиллалаа. Хангарди ордны зоогийн газрын хоол	100%

1	2	3	4	5	6	7	8
						үйлдвэрлэлийн технологийн картыг зууш салат - 23, хачир - 26, соус - 10, ширхгийн хоол - 9, халуун унд - 7, кофе брейк - 32, нэгдүгээр хоол - 25, хоёрдугаар хоол - 47, өглөөний цай - 10 буюу нийт 189 төрлийг багтаан боловсруулж зоогийн газрын өдөр тутмын үйл ажиллагаанд хуваарийн дагуу мөрдөн ажиллаж байна.	
3.14	Арга хэмжээ №3.14 Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа хүндэтгэлийн хүлээн авалт, хурлын цайны завсарлага, хээрийн үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100%	Тайлант хугацаанд нийт 230 удаагийн хурлын цайны завсарлага, хүндэтгэлийн хүлээн авалт, боолтын хоол, катерингийн үйлчилгээгээр нийт 13526 хүнд, 4 удаагийн баяр наадмын арга хэмжээ, хээрийн үйлчилгээгээр шуурхай, чанартай зоогийн үйлчилгээг үзүүлж ажиллалаа.	100%
Зорилт 4. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт							
4.1	Арга хэмжээ №4.1 Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйлчилгээний чанарын талаарх сэтгэл ханамжийн судалгааг авч, үр дүнд хяналт шинжилгээ-үнэлгээ хийж шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх	-	Сэтгэл ханамжийн судалгааны тоо	2	2	Газрын даргын 2023 оны 01 сарын 24-ний өдрийн А/07 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 01 дүгээр сарын 24, 25-ны өдрүүдэд НЗЗ-ны байруудад ажиллаж буй ННЗБ-ын албан хаагчдаас цэвэрлэгээ, үйлчилгээний чанарын талаарх сэтгэл ханамжийн судалгааг 85 төрийн албан хаагчаас авсан. Судалгааны дүнд 55.2% нь сайн, 38.8% нь дунд, 6% нь хангалтгүй гэсэн үнэлгээ өгсөн. Сэтгэл ханамжийн судалгааг 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрөөс 2023 оны 11 дүгээр 10-ны өдрүүдэд сүүлийн хагас жилийн байдлаар НЗЗ-ны байруудад ажиллаж буй ННЗБ-ын албан хаагчдаас цэвэрлэгээ, үйлчилгээний чанарын талаарх сэтгэл ханамжийн судалгааг QR кодоор зохион байгуулсан. Судалгааны дүнд гарсан үнэлгээний дагуу үйлчилгээний чанарт анхааран ажиллаж байна.	100%
4.2	Арга хэмжээ №4.2 Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан холбогдох стандартуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100%	Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/242 захирамжаар батлагдсан “Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай”, “Иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай орчныг бүрдүүлэхэд хууль, норм дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах, хяналт шалгалт хийх ажлын нэгдсэн төлөвлөгөө”- нөөс холбогдох стандартуудыг үйл ажиллагаандаа нийцүүлэн мөрдөж ажиллалаа.	100%

1	2	3	4	5	6	7	8
4.3	Арга хэмжээ №4.3 Засгийн газрын 2021 оны 07 дугаар тогтоолын дагуу шаардлагатай холбогдох арга хэмжээг авч ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100%	ЗГ-ын 2022 оны 7 дугаар тогтоол 5.4-т заасны дагуу албан бичгийг кирилл, үндэсний бичгээр хослуулан хөтлөх ажлын хүрээнд үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх 2 цагийн танхимын, 6 цагийн цахим сургалтыг явуулж 50 албан хаагч хамрагдсан.	100%
4.4	Арга хэмжээ №4.4 “Улаанбаатар 2023” Зүүн Азийн наадмын зохион байгуулалтын бэлтгэл ажлыг ханган хамтран ажиллах, оролцох	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100%	Тус арга хэмжээнд нийт 121 ажилтан, албан хаагчийг оролцуулан нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллалаа.	100%
4.5	Арга хэмжээ №4.5 “Цахим Улаанбаатар” төсөл, “digital first” аяны үйл ажиллагаанд ажилтан, албан хаагчдыг уриалан идэвх санаачилгатай оролцох	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100%	Тус арга хэмжээний талаарх мэдээллийг байгууллагын мэдээллийн эх сурвалжуудаар дамжуулан ажилтан, албан хаагчдад хүргэн ажиллалаа.	100%
4.6	Арга хэмжээ №4.6 Цахим хөгжлийн багц хуулийг боломжит мэдээллийн эх сурвалжуудаар дамжуулан сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100%	Тус арга хэмжээний талаарх мэдээллийг байгууллагын мэдээллийн эх сурвалжуудаар дамжуулан ажилтан, албан хаагчдад хүргэн ажиллалаа.	100%